




БУЯН ӨЛЗИЙ
ХУР ТРАНС

БУЯН ӨЛЗИЙ ХУР ТРАНС ХХК

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН—2024 ОН





АГУУЛГА

- 1. Компанийн тухай**
- 2. Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтууд**
- 3. Нийгмийн хариуцлагын хүрээнд**
- 4. Байгаль орчны хүрээнд**
- 5. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хүрээнд**
- 6. Эдийн засгийн хүрээнд**

1. Компанийн тухай

Бид Монгол Улсын эрдэс баялгийн тээврийн салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж, үр ашигтай шийдэл, найдвартай үйлчилгээгээр тэргүүлэх зорилготойгоор 2010 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Манай компани нь Монгол Улсын Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Таван толгойн бүлэг ордоос тус аймгийн нутаг дэвсгэрт байрлах Гашуун Сухайт боомт болон БНХАУ-ын Ганц Модны боомтын гаалийн хяналтын бүс хүртэлх зайнд Улс хоорондын байнгын ачаа тээврийн үйлчилгээ үзүүлдэг.

Бидний:

Алсын хараа

Хөгжилд тууштай тэмүүлэгч, чанарыг эрхэмлэгч итгэлт түнш

Эрхэм зорилго

Эрдэс баялгийн тээврийг үр ашигтай шийдэл, найдвартай үйлчилгээгээр тэргүүлнэ.

Үнэт зүйлс

- Б – Байгальд болон хүндээ ээлтэй
- Ө – Өрсөлдөх чадвартай, хурдтай
- Х – Хариуцлагатай, ёс зүйтэй
- Т – Тууштай хамт олон



Бидний уриа : *Тээврийг бүтээмжээр тэргүүлнэ.*

2. Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтууд

Бид хууль дээдлэх зарчмыг баримтлан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, үйл ажиллагаандаа байгальд ээлтэй шийдлийг нэвтрүүлэн тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Бидний нийгмийн хариуцлагын хамрах хүрээний дэд зорилтууд:



БАЙГАЛЬ ОРЧИН

Бизнесийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахад өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан хувь нэмрээ оруулах, байгаль орчинд ээлтэй шийдэл нэвтрүүлэх замаар компанийн ажилтан бүр байгаль хамгаалагч байх байгаль орчны бодлого тодорхойлон хэрэгжүүлнэ.



ХҮҮХДИЙН ЭРХ

Хүүхдийн эрхийг эрхэмлэн, хүүхдийн эрх компанийн ажлын орчин болон ажилтнуудын гэр бүлийн орчинд зөрчигдөх аливаа хэлбэрээс сэргийлж, хууль эрх зүйн болоод хүүхэдтэй харилцах ёс зүйн зарчмыг сурталчилна.

Компанийн дэргэд ажилтнуудын хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд зориулсан үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий “Эцэг эхийн зөвлөл” ажиллуулж, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллана.



БОЛОВСРОЛ

Эрэлттэй ажлын байранд компанийн зардлаар суралцуулах, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх замаар иргэдийн мэдлэг, боловсролыг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.



СПОРТ, ЭРҮҮЛ МЭНД

Ажилтныхаа эрүүл мэндийг нэн тэргүүн тавьж, эрүүл аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Нийт ажилтныг эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягт уриалсан спорт арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж, ажилтнуудын дундах спортын өдөрлөг, тэмцээн бүхий үйл ажиллагааг санхүүжүүлнэ.



ТАТВАР, ХУУЛЬ ЁС

Үйл ажиллагаандаа хуулийг сахин дээдэлж, хууль ёсны татварыг бүрэн төлж, улс орны эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулна.



ЯДУУРАЛ, НИЙГМИЙН АМЬДРАЛ

Ган, зуд, гамшиг тохиолдсон үед эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон ард, иргэдийг сэтгэл санаагаар дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцон дотоод нөөц бололцоогоороо дэмжлэг үзүүлнэ.

3. Нийгмийн хариуцлагын хүрээнд:

Бид Монгол Улсын эрдэс баялгийн тээврийн салбарт хариуцлагатай, найдвартай байдлаараа үлгэрлэхийг зорин ажилладаг бөгөөд салбартаа стандарт, үр ашигтай шийдлийг нэвтрүүлэхийг зорин ажиллаж буй үндэсний компани юм.

Бид өнгөрсөн хугацаанд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутаг, бизнесийн хамтрагчид, ажилтнууддаа чиглэсэн олон үйл ажиллагаа зохион байгуулж ажилласан.

3.1. Орон нутгийн хөгжил, оролцоо

Орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, гамшиг тохиолдсон үед хандив тусламж үзүүлэх, эмзэг болон зорилтот бүлгийн иргэдэд хандив тусламж үзүүлэх зэргээр дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэв. Үүнд:



2017 он
Баянхонгор аймгийн Баянхонгор сумын өрх толгойлсон ээжүүдэд 10 ширхэг таван ханатай өргөө цагаан гэр бэлэглэв.



2021 он
Өмнөговь аймгийн Цогтцэций сумын өвөлжилт хүндэрсэн багуудын малчдад 1000 боодол өвс хандивлав.



2024 он
Өмнөговь аймгийн Ханбогд сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн баяр наадамд хандив өгөв.



2024 он
Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтэстэй хамтран "Цагдаа өвлийн өвөө" үйл ажиллагааг зохион байгуулж, ивээн тэтгэж оролцов.

3.2. Ажилтнуудад чиглэсэн арга хэмжээ

Нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх

- Бид ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх хүрээнд ажилтанд тохиолдсон баяр жаргалтай мөчүүдэд зориулсан бэлэг, гачигдал зовлонтой үед нь буцалтгүй тусламж олгохоор Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж хэрэгжүүлэн ажилладаг.

Хөдөлмөрийн дотоод журмын хэсгээс

2.8. Шагнал, бэлэг

2.8.1. Компанид өндөр үр бүтээлтэй ажиллаж, хамт олондоо сайн жишиг, үлгэр дуурайл үзүүлсэн, компанийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлсэн болон компанид тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудыг байгууллагын шагналаар шагнаж, эсхүл холбогдох холбоод, төрийн байгууллагад уламжлан шагналд тодорхойлно.

2.8.2. Байгууллагын шагналын төрөл, төсөв, шалгаруулалтын зарчмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, нийт ажилтнуудад танилцуулна.

2.8.3. Ажилтан төрийн байгууллага болон мэргэжлийн холбоод, эсхүл гадаад улсын шагналаар шагнагдсан бол компаниас бэлэг олгож болох ба бэлгийн төсөв зардлыг Гүйцэтгэх захирал батална.

2.8.4. Ажилтан төрийн байгууллага болон мэргэжлийн холбоод, эсхүл гадаад улсын шагналыг дагалдаж олгогдох мөнгөн шагналыг ААНБ нь олгохоор журамлагдсан тохиолдолд компаниас зардлыг гаргаж Гүйцэтгэх захирлын тушаалаар мөнгөн шагналыг олгож болно.

2.8.5. Ажилтан нь сахилгын зорчилтэй, эл хөрөнгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шагналд тодорхойлоход харгалзана.

2.8.6. Компанийн зүгээс ажилтнууддаа дараах бэлгүүдийг олгоно. Доорх бэлгийн дүн нь татвар суутгалын дараах дүн болно. Үүнд:

2.8.6.1. Компанийн ажилтан гэрлэлтээ албан ёсоор батлуулан тэмдэглэж байгаа тохиолдолд гэрлэлтийн гэрчилгээнд үндэслэн хуримын бэлэг 500,000 (таван зуун мянга) төгрөгийг;

2.8.6.2. Компанийн ажилтан хүүхэдтэй болоход хүүхдийн төрсний гэрчилгээнд үндэслэн 100,000 (нэг зуун мянга) төгрөг;

2.8.6.3. Компанийн ажилтнуудын хувийн мэдээлэлд үндэслэн 16 хүртэлх настай хүүхэд бүрт жил бүрийн 6-р сарын 1-ний өдөр Хүүхдийн баярын бэлэг;



2.8.6.4. Компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан болон эмэгтэй 50 нас, эрэгтэй 55 нас-с дээш насны ажилтнуудад Цагаан сарын баярыг тохиолдуулан Ахмад настны бэлэг тус тус бэлэглэнэ.

2.9. Хангамж, хөнгөлөлт, буцалтгүй тусламж

2.9.1. Ажилтанд ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор дараах хангамж, хөнгөлөлтийг олгож болно. Үүнд:

2.9.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын ажлын болон амрах байр;

2.9.1.2. Стандартын шаардлага хангасан техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон багаж хэрэгсэл, ажлын хувцас, бичгийн хэрэгсэл, програм хангамж;

2.9.1.3. Ажил олгогчийн хариуцлагын даатгалын хамгаалалт;

2.9.1.4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэг;

2.9.1.5. Утасны төлбөрийн хөнгөлөлт;

2.9.1.6. Унааны болон шатахууны хөнгөлөлт;

2.9.1.7. Хоолны мөнгө;

2.9.2. Ажилтны ар гэрийн гачигдал, гэнэтийн уй гашууг хуваалцаж, сэтгэлийн дэм өгөх зорилгоор дараах буцалтгүй тусламжийг холбогдох баримтыг үндэслэн олгоно. Үүнд:

2.9.2.1. Ажилтны эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас нөгчсөн тохиолдолд нас барсны гэрчилгээг үндэслэн 800,000 (найман зуун мянга) төгрөг;

2.9.2.2. Ажилтны өрх тусгаарлаагүй буюу нэг гэрт цуг амьдардаг төрсөн ах, эгч, дүү, хадам аав, ээж нас нөгчсөн тохиолдолд иргэний үнэмлэхний хаягийн бүртгэл, нас барсны гэрчилгээг үндэслэн 500,000 (таван зуун мянга) төгрөг;

[Энэ заатгад гүйцэтгэх захирлын 2024 оны 05-р сарын 01-ний өдрийн дугаар А-25-01 тушаалаар өөрчлөлт оруулсан.](#)

2.9.2.3. Ажилтан өөрөө нас нөгчсөн тохиолдолд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.

2.9.2.4. Ажилтны амьдардаг гэр, байшин, орон сууц нь байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдэн ажилтан болон түүний гэр бүл орох оронгүй болсон тохиолдолд Гүйцэтгэх захирлын тушаалаар нэг удаагийн буцалтгүй тусламж олгож болох ба энэ тохиолдолд гамшиг, давагдашгүй хүчин зүйлийг үнэлэх мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон холбогдох баримт, тодорхойлолтыг үндэслэнэ.

2.9.3. Ажилтанд олгох хангамж, хөнгөлөлт болон буцалтгүй тусламжийн төрөл, хэмжээ, шаардагдах төсвийг Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн тогтоож болно.

2.9.4. Дээрх нөхцлөөс бусад тохиолдолд хангамж, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг ач холбогдол, хэрэгцээ шаардлага зэрэгт тулгуурлан санхүүгийн чадамжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын тушаалаар олгож болно.

- Хөдөлмөрийн тухай хуулийн «109.9.Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй» гэж заасан боловч Цагаан сар, Үндэсний их баяр наадам» зэрэг нь Монгол айл гэр бүлийн чухал тэмдэглэлт баяр гэж үзэн энэ өдрүүдэд байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд ээлжийн хуваарийн дагуу ажилласан ажилтнуудын цалин хөлсийг 2 дахин нэмж тооцон олгодог байхаар Компанийн дотоод журманд тусган хэрэгжүүлж ажилладаг.
- Бид өнгөрсөн хугацаанд байгууллагадаа тогтвор суурьшилтай, өндөр үр бүтээлтэй ажилласан нийт 8 ажилтанд «Орон сууцны дэмжлэг үзүүлж», байрны урьдчилгаа төлбөрт зориулан **500 сая** төгрөгийг олгосон байна.

Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх хүрээнд

- Хамт олныг эв найртай, эерэг байлгах, багийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд нийтийг хамарсан арга хэмжээг Хүний нөөцөөс гаргасан төлөвлөгөөний дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

АХМАД НАСТНУУДАА ХҮНДЭТГЭХ—Цагаан сар, Ахмадын баяраар



ШИНЭ ЖИЛИЙН БАЯР - ШИЛДЭГ АЖИЛТНУУД



3.3. Спорт, эрүүл мэнд


Ажилтан бол нийгмийн нэг хэсэг юм. Ажилтан эрүүл, зөв амьдралын хэвшилтэй байж, эрүүл мэндийн боловсролтой, эрүүл мэнддээ анхаардаг байх нь компанийн зүгээс Эрүүл монгол хүнийг бүтээлцэхэд хувь нэмрээ оруулж буй хэлбэр гэж үздэг.

Тиймээс Эмч эрүүл ахуйчийн үндсэн орон тоонд Хүний их эмч ажиллуулж, ажилтнуудын эрүүл мэндэд тогтмол хяналт тавьж, зөвлөгөө мэдээллээр ханган ажилладаг. Мөн жил тутам ажилтнаа эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт байгууллагын зардлаар хамруулдаг. Эрүүл мэнд, өвлөлийн байдалд тандалт судалгаа хийж, эрүүлжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллалаа.



Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, дасгал хөдөлгөөнтэй идэвхтэй амьдралд уриалах зорилгоор жил бүр БӨХТ спорт өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

Мөн салбарын спортын арга хэмжээ, үйл ажиллагаанд хамт олноороо идэвхтэй хамрагдаж оролцдог. Мөн кемпийн бүсийн гадна талбайд сагс, гар бөмбөгийн талбай зассан, фитнесийн өрөөг тохижуулсан болно.



3.4. Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал

Хүүхэд хамгааллын бодлого

Бид хамтын ажиллагаа, гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, дотоод нөөцдөө түшиглэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

Зорилт:

- Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүндэтгэн, компанийн нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын зарим чиглэлийг хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлнэ.
- Ажлын орчин, ажилтны гэр бүлд хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд хүүхдийн эрхийг зөрчдөг этгээдтэй хамтран ажиллахгүй, хэрэв үйл баримт тогтоогдвол хамтын ажиллагааг цуцална.
- Ажлын цагийг уян хатан зохион байгуулалтаар хангах, хөдөлмөрийн харилцаандаа зайнаас ажиллах, гэрээсээ ажиллах, ажлын бүтэн бус цагаар ажиллах гэх мэт уян хатан боломжуудыг судлан, боломжит хувилбарыг хэрэглэх замаар ажилтны ажил, амьдралын тэнвцэрийг хангана.
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж”-ийн дагуу ажилтнуудын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг дотоод нөөцөд түшиглэн зохион байгуулж, үйл ажиллагааг баримтжуулж ажиллана.
- Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр ажилтнуудад чиглэсэн сургалтыг дотоод сургалтын төлөвлөгөөнд оруулан байнгын давтамжтай сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр мэргэжлийн байгууллагатай хамтран ажилтан, тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулна.
- Хүүхэд хөгжих, эрүүл аюулгүй хараа хяналттай байх боломжийг бүрдүүлэх, ажилтны хүүхдэд учирч болох эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг дотоод нөөц бололцоондоо түшиглэн хэрэгжүүлэх зэргээр хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- Компанийн ёс зүйн дүрэм, ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд хүүхэдтэй харилцах ёс зүйн хэм хэмжээг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавин хүүхэдтэй холбоотой аливаа зөрчлийг мэдээлэх соёл төлөвшүүлнэ.
- Хүүхдэд хор хохирол учруулж болзошгүй хүнийг ажилд орохоос урьдчилан сэргийлж, хүүхэдтэй зүй бусаар харьцаж байсан эсэхийг нягтална.

Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж, жил бүрийн “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-өөр ажилтнуудын хүүхэд бүрт гарын бэлэг бэлдэж, хүүхэд багачуудад зориулсан үйл ажиллагааг дэмжин зохион байгуулдаг.



БӨХТ хүүхдүүдэд зориулсан Пороро ба түүний найзууд, Музейн аялал, Гар зургийн уралдаан зэрэг олон арга хэмжээг зохион байгуулсан.



4. Байгаль орчны хүрээнд

Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого

Эрдэс баялгийн тээвэрлэлтийг харилцагчийн хүлээлтэд нийцсэн аюулгүй, найдвартай, хурдтай, байгаль орчинд ээлтэй шийдлээр Чанар, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, Байгаль орчин, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын стандарт болон Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, үйл ажиллагаагаа байнга сайжруулснаар Монгол Улсын хөгжилд тууштай хувь нэмрээ оруулна.

Байгаль орчны зорилт

- Тээвэрлэлтээс үүсч болох байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, бууруулах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлнэ.
- Бүх түвшний удирдлага Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад манлайлагч байж, ажилчдад зөв үлгэр дуурайлал үзүүлнэ.
- Тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүдэн гарах хүлэмжийн хий, тоосжилт, эрчим хүчний хэрэглээг бууруулахад үр ашигтай, ногоон шийдлийг нэвтрүүлж, хувь нэмрээ оруулна.
- Энгийн болон аюултай хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.
- Байгалийн нөөц, унаган төрхийг хадгалах, хамгаалахад ажилтан бүр идэвхтэй оролцоотой байна.

Хийж гүйцэтгэсэн ажлууд

- 2022 – Өмнөговь аймгийн Ханбогд сум Цагаан хад суурьшлын бүсэд байрлах ажилчдын хотхонд Бохир ус цэвэршүүлэх ТОПАС 10пр, 20 пр төхөөрөмжүүдийг суурилуулан байгаль орчинд ямар ч хор нөлөө үзүүлэхгүйгээр бохир усыг 98% цэвэршүүлж байна. Цэвэршүүлсэн саарал ус нь MNS 4943:2011 стандартын шаардлагыг бүрэн хангадаг.



- Дэд бүтцээ бүрэн шийдвэрлэсэн зөөврийн сууц бүхий ажилчдын байруудаар кемпийн өргөтгөл хийж нүхэн жорлонгийн тоог бууруулав.



- 2020-2023—Тээврийн хэрэгслүүдэд үе шаттай парк шинэчлэл хийж, байгальд ээлтэй, түлш зарцуулалтад хэмнэлттэй, евро-3 стандартын тээврийн хэрэгслүүдийн худалдан авалт хийв. Цаашдаа байгальд ээлтэй, үр ашигтай, илүү боловсронгуй шийдлийн судалгаа хийж байна.



- 2024 онд—Аюултай хог хаягдлыг ангилан цуглуулж, устгуулахаар тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай (Ханбогд вест менежмент ХХК) хамтын ажиллагааг эхлүүлэв.
- 2025 онд Олон улсын ISO14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо нэвтрүүлэх үйл ажиллагааг эхлүүлж, үйл ажиллагаандаа зөрүүгийн шинжилгээ хийн, залруулах ажиллагаа хийгдэж байна. Үүнтэй холбоотойгоор хөрс, усны бохирдлын шинжилгээ хийлгэв.

- Кемпийн бүст болон гадна талбайд өдөр тутмын болон бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж ажилтнууд идэвхтэй оролцдог.



5. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хүрээнд

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (ХЭМАБ)-ын зорилт:

- Бүх түвшний удирдлага ХЭМАБ-ын манлайлагч байж, ажилчдад зөв үлгэр дуурайлал үзүүлнэ.
- Ажилтан бүр оролцоотой байж, аюулгүй ажиллах мэдлэг, арга барилыг эзэмшиж, үл буруутгах зарчмыг баримтална. ХЭМАБ бол ажилтан бүрийн хариуцлага юм.
- Ажилтны оролцоо, санал санаачилга, ХЭМАБ-ын сайн гүйцэтгэлийг дэмжин урамшуулна.
- Аюулыг нээлттэй мэдээлэх тогтолцоо болон дотоод хяналт шалгалтын үр дүнгээр аюулаас урьдчилан сэргийлж, залруулах арга хэмжээ авна.
- Осол болон осолд дөхсөн тохиолдлуудыг тухай бүр судлан бүртгэж, дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ.
- Эрдэс баялгийн тээврийн салбарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлснээр замын хөдөлгөөний дүрмийг баримтлагч, замын хөдөлгөөний соёлыг түгээгч болно.

Бид үүсгэн байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл «Эрүүл жолооч—Аюулгүй тээвэр» урианд нэгдэн согтууруулах ундааны хэрэглээг хатуу хориглодог бөгөөд аялал эхлэх үед, тээвэрт гарах бүрт, тээвэрлэлтийн үед төлөвлөгөөт болон гэнэтийн сорил авч, хяналт тавин, «Ажлын байран дээр архи согтууруулах ундаа» хэрэглэсэн зөрчлийг Хөдөлмөрийн сахилгын ноцтой зөрчил гэж үзэн Хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах арга хэмжээг авдаг.

Аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор ажилтанд зориулсан амь нас эрүүл мэндийн даатгал, тээврийн хэрэгсэлд зориулсан албан журмын, тээврийн хэрэгслийн даатгалуудад хамрагддаг.

2018 оноос хойш жилд 2 удаа ХАБЭА-н нийт ажилтны сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Сургалтанд тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцдог төр захиргааны байгууллагууд, компаниудтай хамтран зочин илтгэгч урьж оролцуулдаг уламжлалтай. Үүнд: Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ, Эрдэнэс таван толгой ХК, Тээврийн цагдаагийн газар, Гаалийн газар, Гашуун сухайт боомтын ажлын хэсэг, Онцгой байдлын газар гэх мэт



6. Эдийн засгийн хүрээнд

Бидний алсын хараа, эрхэм зорилгод «ИТГЭЛТ ТҮНШ» байхыг тодорхойлсон бөгөөд энэ нь «бид хамтын ажиллагаандаа чанар, хариуцлага, тэгш байдлыг эрхэмлэн ажиллах ба ажилтан, ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч болон сонирхогч хэн бүхний итгэлийг даасан хамтрагч байна.» гэсэн утгыг илэрхийлж байгаа юм. Үүний тулд бид Монгол улсын хууль дүрэм журмыг чанд баримтлан ногдох татвар шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр үнэнч шударгаар төлдөг бөгөөд ажилтнуудын цалин хөлсийг хууль салбарын жишиг стандарт, дүрэм журмын дагуу тооцож олгодог.



Төлсөн татварын хэмжээ:

Сүүлийн 2 жил буюу 2023-2024 онд бид улсад 1,437,782,316 төгрөгийн татварыг төлсөн байна. Үүнд: ААНОАТ, НӨАТ, ХХОАТ, Тээврийн хэрэгслийн татвар, бусад татвар хамаарна.



Төр захиргааны байгууллагад төлсөн хураамж, цалин хөлс, шимтгэлийн хэмжээ:

Сүүлийн 2 жил буюу 2023-2024 онд бид 403 сая төгрөгний хураамж төлж, 11 тэрбум 190 сая төгрөгний цалин хөлсийг олгож, 1,5 тэрбум төгрөгийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн байна.




Бидний оролцоо

Эрдэс баялгийн салбарын орлого төсвийн нийт орлогын 40-50%-ийг бүрдүүлдэг, экспортын гол бүтээгдэхүүний 90 орчим хувийг эзэлдэг стратегийн чухал ач холбогдол бүхий салбар юм.

Бидний үйл ажиллагаа явуулж буй Гашуун сухайт – Ганц мод боомтоор нүүрсний нийт экспортын 80-90 нь тээвэрлэгдэж гардаг бөгөөд Монголын эдийн засгийн чухал гарц юм.

Бид сүүлийн 3 жилийн хугацаанд л гэхэд Гашуун сухайт Ганц мод боомтоор «1 сая тонн» нүүрсийг улс хооронд тээвэрлэж Монгол улсын эдийн засагт өөрсдийн хувь нэмрээ оруулан ажилласан байна.




Бид байгаль ээлтэй, дэвшилтэт технологийг ашиглан өндөр бүтээмжтэй тээвэрлэлтийг гүйцэтгэх замаар Монгол улсын эдийн засагт өөрсдийн хувь нэмрээ оруулан ажилласаар байна.





БУЯН ӨЛЗИЙ ХУР ТРАНС

ПЭЭВРИЙТ БҮЛЭЭМЖЭЭР ПЭРТҮҮЛНЭ.



2024 он